ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДОА-2020/150/СТА-ТШЗ

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Э.Нандинчимэг
Утас: 7000-3775 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ЗТХС | Зам Тээвэр Хөгжлийн Сайд |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## Агуулга


Аудитын гэрчилгээ ........ 1
Аудитын тайлан ........ 3
- 2.1. Оршил ........ 3
- 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 3
- 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 3
- 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 4
- 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 4
- 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 4
- 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 4
- 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 5
- 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 5
- 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 6
- 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 6
- 2.12. Шилэн дансны мэдээлэл ........ 6
- 2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 7
- 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 7

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ........ 8
- 3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 8
- 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 9
- 3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 11
- 3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 12
- 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 13

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 204

танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.ЦОГЗОЛМАА ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520118

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Дашбалбар сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Л.Цогзолмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан

үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дашбалбар сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Үндэсний уламжлалт ёс заншилаа дээдлэн өв соёлоороо бахархсан эх оронч сэтгэлгээтэй иргэн байх төлөвшилийг багаас олгох”-д оршино.

Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын сургалтыг сайжруулсан цөм хөтөлбөрийн хүрээнд өөрийн цэцэрлэгийн үзэл баримтлалаа дээдлэн багш бүр өдөр тутмын үйл ажиллагааг чанартай бэлтгэн зохион байгуулж хүүхэд нэг бүрийн хөгжилд ахиц гарган багш эцэг эхийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж хамтран ажиллах

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дашбалбар сумын Цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Дашбалбар сумын Цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Дашбалбар сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн

эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 391,438.1 мянган төгрөгөөс тооцон 5,871.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 269.1 мянган төгрөгөөр буюу 0.078 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 40,309.03 | 53,520.75 | 13,211.72 |
| Үндсэн хөрөнгө | 357,164.35 | 367,712.35 | 10,548.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (54,938.01) | (78,966.92) | (24,028.91) |
| **Нийт хөрөнгө** | **342,535.37** | **342,266.18** | **(269.19)** |
| Өр төлбөр | | | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 342,535.37 | 342,266.18 | (269.19) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **342,535.37** | **342,266.18** | **(269.19)** |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Аж ахуйн материал 3.2 сая, Барилгын материал 1.3 сая, Бусад хангамжийн материал 5.5 сая, Мал амьтад 2.9 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 9,8 сая төгрөгөөр Халаалтын тогоо, 902.0 мянган төгрөгөөр хувилагч машин авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 342,266.1 мянган төгрөг болж 269.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 376,806.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 350,446.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 26,360.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 376,749.8 мянган төгрөг буюу 99,98 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн дансанд 902.0 мянган төгрөгийн орлого орж, зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

### 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл тогтоож 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 48,060.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 47,147.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 913.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Аудитаар дараах 48,060.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд гарсан зардлаас 47,147.2 мянган төгрөгийн зардлыг ибаримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллалаагүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

1. Тендерээр шалгарсан байгууллагатай хийсэн гэрээний үнээс гүйцэтгэлээрх худалдан авалтын үнэ 913.4 мянган төгрөгөөр илүү байгаа нь Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” , Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.1 дэх хэсэгт “Худалдан авах гэрээнд өөрчлөлт хийхийг хориглоно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийн хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Худалдан авалтын гэрээний нэгжийн үнэ, түүний өөрчлөлтийг нягтлан шалгах.

### 2.12. Шилэн дансны мэдээлэл

Дашбалбар сумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дашбалбар сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,309,033.00** | **53,520,752.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 40,309,033.00 | 53,520,752.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 36,849,033.00 | 47,105,752.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 36,849,033.00 | 40,146,952.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 1,372,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 5,586,800.00 |
| 35600 | Мал амьтад | 3,460,000.00 | 6,415,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **302,226,338.13** | **288,745,425.36** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 302,226,338.13 | 288,745,425.36 |
| **392** | **Биет хөрөнгө** | 280,617,171.38 | 267,290,258.57 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 251,461,983.88 | 261,261,983.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | (12,938,879.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,110,668.00 | 40,012,668.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,914,560.11) | (33,641,183.70) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,902,291.00 | 17,902,291.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,823,423.11) | (11,559,842.19) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 26,893,940.00 | 26,893,940.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (17,200,028.28) | (20,827,018.98) |
| 39217 | Ном | 186,300.00 | 186,300.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 21,609,166.75 | 21,455,166.79 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (320,833.25) | (474,833.21) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 21,160,000.00 | 21,160,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **342,535,371.13** | **342,266,177.36** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **342,535,371.13** | **342,266,177.36** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 342,535,371.13 | 342,266,177.36 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 161,709,693.00 | 161,709,693.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 161,709,693.00 | 161,709,693.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 74,760,224.74 | 74,491,030.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 74,760,224.74 | 74,760,224.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (269,193.77) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 106,065,453.39 | 106,065,453.39 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **342,535,371.13** | **342,266,177.36** |

### 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **299,084,873.00** | **391,168,945.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **286,661,573.00** | **390,266,945.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,392,300.00 | 3,660,945.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,392,300.00 | 3,660,945.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 3,050,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,392,300.00 | 610,945.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 277,269,273.00 | 386,606,000.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 277,269,273.00 | 350,446,000.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | - | 9,800,000.00 |
| 123004 | Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг | - | 26,360,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **12,423,300.00** | **902,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,423,300.00 | 902,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,423,300.00 | 902,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **313,399,094.54** | **391,438,138.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **313,399,094.54** | **391,438,138.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 309,987,761.52 | 390,781,974.88 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 183,273,490.00 | 249,569,874.00 |
| 210101 | Үндсэн цалин | 129,360,676.00 | 188,474,190.00 |
| 210102 | Нэмэгдэл | 20,005,145.00 | 42,266,007.00 |
| 210104 | Урамшуулал | 17,012,800.00 | 18,829,677.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,894,869.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,388,342.98 | 32,335,966.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,996,756.04 | 22,077,566.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,874,966.94 | 2,564,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,469,733.00 | 2,051,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 330,687.00 | 512,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,716,200.00 | 5,129,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,575,434.00 | 23,207,871.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,707,886.00 | 5,940,573.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,315,498.00 | 15,767,298.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,552,050.00 | 1,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,113,905.00 | 9,337,960.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 876,300.00 | 911,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,398,670.00 | 1,868,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 314,200.00 | 562,188.30 |
| 210404 | Ном, хэвлэл | 60,000.00 | 22,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,464,735.00 | 5,973,732.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,625,073.00 | 46,606,070.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 83,300.00 | 102,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,809,773.00 | 46,366,770.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 732,000.00 | 137,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,332,120.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,332,120.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 354,000.00 | 1,378,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 354,000.00 | 1,378,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 270,000.00 | 1,185,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 90,000.00 | 1,025,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32,387,516.54 | 25,828,612.77 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,181,244.00 | 95,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 447,300.00 | 1,550,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,758,972.54 | 24,182,912.77 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,411,333.02 | 656,163.89 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,237,000.00 | 600,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,237,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 174,333.02 | 56,163.89 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 174,333.02 | 56,163.89 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(14,314,221.54)** | **(269,193.77)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 50,879,375.01 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,416,800.24 | - |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 45,462,574.77 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (50,879,375.01) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(65,193,596.55)** | **(269,193.77)** |

### 3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **289,692,573.00** | **377,708,000.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **277,269,273.00** | **376,806,000.00** |
| 123 | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 277,269,273.00 | 376,806,000.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 277,269,273.00 | 350,446,000.00 |
| 123004 | Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг | - | 26,360,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **12,423,300.00** | **902,000.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,423,300.00 | 902,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,423,300.00 | 902,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **289,692,573.00** | **377,708,000.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **289,692,573.00** | **377,708,000.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **286,281,239.98** | **377,051,836.11** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 183,273,490.00 | 249,569,874.00 |
| 210101 | Үндсэн цалин | 129,360,676.00 | 188,474,190.00 |
| 210102 | Нэмэгдэл | 20,005,145.00 | 42,266,007.00 |
| 210104 | Урамшуулал | 17,012,800.00 | 18,829,677.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,894,869.00 | - |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,388,342.98 | 32,335,966.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,996,756.04 | 22,077,566.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,874,966.94 | 2,564,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,469,733.00 | 2,051,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 330,687.00 | 512,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,716,200.00 | 5,129,100.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,575,434.00 | 23,207,871.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,707,886.00 | 5,940,573.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,315,498.00 | 15,767,298.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,552,050.00 | 1,500,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 6,369,900.00 | 9,985,499.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 876,300.00 | 911,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,398,670.00 | 1,868,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 314,200.00 | 562,188.30 |
| 210404 | Ном, хэвлэл | 140,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,640,730.00 | 6,393,671.00 |
| 2105 | **Норматив зардал** | 45,625,073.00 | 48,164,625.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 83,300.00 | 102,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,809,773.00 | 46,089,325.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 732,000.00 | 1,973,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 4,052,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 902,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 3,150,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 354,000.00 | 1,378,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 354,000.00 | 1,378,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 270,000.00 | 6,718,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 90,000.00 | 6,558,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 160,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,425,000.00 | 1,640,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,000,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 425,000.00 | 1,640,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,411,333.02** | **656,163.89** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,237,000.00 | 600,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,237,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 600,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 174,333.02 | 56,163.89 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 174,333.02 | 56,163.89 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 0.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 161,709,693.00 | 106,065,453.39 | 74,760,224.74 | - | 342,535,371.13 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,760,224.74** | - | **342,535,371.13** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,760,224.74** | - | **342,535,371.13** |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,760,224.74** | - | **342,535,371.13** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,760,224.74** | - | **342,535,371.13** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (269,193.77) | - | (269,193.77) |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **161,709,693.00** | **106,065,453.39** | **74,491,030.97** | - | **342,266,177.36** |

### 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **376,806,000.00** | **376,749,836.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **376,806,000.00** | **376,749,836.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 376,206,000.00 | 376,149,836.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 249,572,500.00 | 249,569,874.00 |
| 210101 | Үндсэн цалин | 179,219,400.00 | 188,474,190.00 |
| 210102 | Нэмэгдэл | 40,691,100.00 | 42,266,007.00 |
| 210104 | Урамшуулал | 29,662,000.00 | 18,829,677.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,367,500.00 | 32,335,966.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,109,100.00 | 22,077,566.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,564,800.00 | 2,564,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,051,600.00 | 2,051,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 512,900.00 | 512,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,129,100.00 | 5,129,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,210,000.00 | 23,207,871.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,700,000.00 | 5,940,573.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,010,000.00 | 15,767,298.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,005,100.00 | 9,985,499.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 900,000.00 | 911,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,648,600.00 | 1,868,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 544,500.00 | 562,188.30 |
| 210404 | Ном, хэвлэл | 250,000.00 | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,662,000.00 | 6,393,671.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 48,164,900.00 | 48,164,625.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 102,300.00 | 102,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,089,600.00 | 46,089,325.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,973,000.00 | 1,973,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,150,000.00 | 3,150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,150,000.00 | 3,150,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,378,000.00 | 1,378,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,378,000.00 | 1,378,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,718,000.00 | 6,718,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,558,000.00 | 6,558,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,640,000.00 | 1,640,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,640,000.00 | 1,640,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 600,000.00 | 600,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 600,000.00 |